



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 467 дугаар тогтоолын 2.1 дэх тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 14 нэрийн, нийт 399,567,911.23 (гурван зуун ерэн есөн сая таван зуун жаран долоон мянга есөн зуун арван нэгэн төгрөг хорин гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал К.Эрдэнэбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.4. Тээврийн хэрэгслийг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132000013
3-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны дугаар сарын н-н өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт

**"УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ
ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Үйлдвэрл эсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1	Зил 131 маркийн, тусгай зориулалттай, УББ-4095 улсын дугаартай, 844332 арлын дугаартай	1990.10.01	1990	ш	1	8,566,245.44	8,566,245.44	1,600,000.00
2	Ачааны автомашин капстер, ачааны зориулалттай, УНЭ - 4425 улсын дугаартай, LJN0KB523CX128612 арлын дугаартай	2012.07.01	2012	ш	1	34,937,727.30	34,937,727.30	3,500,000.00
3	Ачааны автомашин капстер, ачааны зориулалттай, УНЭ - 4431 улсын дугаартай, LJN0KB521CK128608 арлын дугаартай	2012.07.01	2012	ш	1	40,465,000.00	40,465,000.00	4,700,000.00
4	УАЗ-фургон маркийн, автобус зориулалттай, УБР-4435 улсын дугаартай, 374100B0466412 арлын дугаартай	2012.01.01	2011	ш	1	20,124,636.37	20,124,636.37	1,800,000.00
5	Ниссан кабстар маркийн, ачаа зориулалттай, УНЭ-4474 улсын дугаартай, LJNCKB534BX290088 арлын дугаартай	2011.07.31	2011	ш	1	46,892,651.60	46,892,651.60	3,700,000.00
6	Ниссан кабстар маркийн, ачаа зориулалттай, УНЭ-4476 улсын дугаартай, LJNCKB539BX290085 арлын дугаартай	2011.06.01	2011	ш	1	53,259,377.68	53,259,377.68	4,500,000.00
7	Тоёота бревис маркийн, суудлын зориулалттай, УНЧ-4791 улсын дугаартай, JCG100048591 арлын дугаартай	2011.01.01	2001	ш	1	13,715,001.00	13,715,001.00	2,540,000.00
8	Тоёота Ландкрузер 80 маркийн, суудлын зориулалттай, УНЗ -5630 улсын дугаартай, HDJ810047067 арлын дугаартай	2007.08.24	1994	ш	1	21,978,000.00	21,978,000.00	1,800,000.00
9	Элентра маркийн, суудлын зориулалттай, УНБ -7301 улсын дугаартай, KMNDT41BABU247064 арлын дугаартай	2014.09.30	2011	ш	1	25,924,807.54	25,924,807.54	1,305,000.00

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Үйлдвэрл эсэн он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
10	УАЗ фургон маркийн, автобус зориулалттай, УНЦ -7695 улсын дугаартай, 374100C0487274 арлын дугаартай	2013.05.01	2012	ш	1	21,713,637.18	21,713,637.18	2,200,000.00
11	Фургон УАЗ-22069 маркийн, автобус зориулалттай, УНУ- 7846 улсын дугаартай, 374100C0483561 арлын дугаартай	2013.05.23	2012	ш	1	6,595,766.21	6,595,766.21	1,860,000.00
12	Универсаль трактор WZ30-25 маркийн, механизм зориулалттай, УБ-8465 улсын дугаартай, 00804018 арлын дугаартай	2008.12.30	2008	ш	1	62,717,060.91	62,717,060.91	1,400,000.00
13	Рио суудлын автомашин, суудлын зориулалттай, УНБ-9091 улсын дугаартай, KNADE221296474183 арлын дугаартай	2009.10.30	2009	ш	1	23,373,000.00	23,373,000.00	552,000.00
14	Киа рио маркийн, суудлын зориулалттай, УНТ-9406 улсын дугаартай, KNADH411AC6868065 арлын дугаартай	2013.04.30	2011	ш	1	19,305,000.00	19,305,000.00	780,000.00
Нийт дүн							399,567,911.23	32,237,000.00
							(гурван зуун ерэн есөн сая таван зуун жаран долоон мянга есөн зуун арван нэгэн төгрөг хорин гурван мөнгө)	(гучин хоёр сая хоёр зуун гучин долоон мянга)